

БХИС-ийн захирлын 2011 оны 11
дүгээр сарын 22 –ны өдрийн 676
дугаар тушаалын хавсралт

БХИС-ИЙН СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ДАДЛАГА, ЧАДВАРЫГ ДҮГНЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

1.1. Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайдын 2003 оны 158 дугаар тушаалаар баталсан **“Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг чадварыг дүгнэхэд баримтлах журам”**-ыг үндэслэн боловсруулсан энэхүү журмыг Монгол Улсын БХИС-ийн хэмжээнд дагаж мөрдөнө.

1.2. Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн хөтөлбөрийн дагуу суралцагчийн (БХИС-ийн докторант, магистрант, оюутан, сонсогч, сурагчдыг энэхүү журамд суралцагч гэж нэрлэв) эзэмшвэл зохих мэдлэг, дадлага, чадварын түвшинг үнэлж, дүгнэх хэлбэр нь явцын болон хөндлөнгийн үнэлгээ байна.

1.3. Суралцагчийн мэдлэг, дадлага, чадварыг үнэлж дүгнэхдээ тэдний бие даан суралцаж “мэдлэг бүтээх” үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, суралцагчийн сурах, багшийн сургах үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгоно.

1.4. Суралцагчийн мэдлэг, дадлага, чадварыг дүгнэх үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэлтэй бодитой, шударга, ил тод байх зарчмаар явагдана.

1.5. Ижил мэргэжлээр суралцаж буй өдөр, эчнээ ангийн суралцагчдын мэдлэг, дадлага, чадварыг хичээлийн нэгэн ижил хөтөлбөрийн агуулгаар шалгаж дүгнэнэ.

1.6. Куррациар хичээллэж байгаа ангийн суралцагчдаас нэгэн төрлийн хичээлийн шалгалтыг тест, бичгийн хэлбэрээр авах тохиолдолд түүний нууцлалыг хангахын хамт шалгалтын өөр хэлбэрийг сонгохыг чухалчилна.

1.7. Суралцагч тодорхой хичээлийн шалгалтыг хүндэтгэн үзэх шалтгаанаар (өвчлөх, улсын болон олон улсын чанартай олимпиад, тэмцээн, уралдаанд оролцох, удаан хугацаагаар чөлөө авах) тогтоосон хугацаанд өгөх боломжгүй болсон нөхцөлд энэ тухайгаа мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын албанд өргөдөл гарган дараагийн улирлын хуваарьт өдөр тухайн хичээлийн нөхөн шалгалт өгөх зөвшөөрөл авна.

1.8. Оюутан тухайн хичээлээр өөрийн мэдлэг, дадлага, чадварыг хангалттай гэж үзвэл багц цаг шууд тооцох 40 хүртэл онооны шалгалтад орох өргөдлөө бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын албанд гаргаснаар шалгалт өгч болно.

1.9. Багц цаг шууд тооцох шалгалтыг томилогдсон комисс улирлын эхэнд авах ба шалгалтад орохын өмнө тухайн хичээлийн үнэлгээний 30 хувийн

төлбөрийг төлсөн байна. Шууд тооцуулах шалгалт нь өдрийн ангийн оюутны хувьд зөвхөн ерөнхий суурь хичээлд, эчнээ ангийн оюутны хувьд ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлд нэг улиралд 2-оос илүүгүй хичээлд зөвшөөрөгдөнө.

1.10. Энэхүү шалгалтыг амжилттай өгсөн оюутны шалгалтад авч болох 40 хүртэлх оноог 2,5 гэсэн оноогоор үржүүлэн уг хичээлийг бүтэн үнэлэх 100 хүртэл оноонд шилжүүлнэ. Шалгалтын эцсийн үнэлгээг хангалтгүй гэж үзвэл тухайн хичээлийг дахин судлана.

1.11. Дахин болон нөхөн шалгалтыг дараагийн улирлын эхний 3 долоо хоногт багтаан тусгай хуваариар авна.

1.12. Мэргэжлийн болон үйлдвэрлэлийн (мэргэших) дадлагын тайланг дадлага дууссан өдрөөс хойш 3 долоо хоногийн дотор, ангийн ажил (тайлан)-ыг хичээл дуусахаас 2 долоо хоногийн өмнө хамгаалуулна.

1.13. Сургалтын төлбөрөө бүрэн төлөөгүй болон тодорхой шалтгаанаар шалгалтад орох зөвшөөрөл олгогдоогүй оюутны нэрийг шалгалтын дүнгийн хуудсанд бичихгүй ба тухайн оюутныг шалгалтад оруулахгүй.

ХОЁР. СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

2.1. Сургалтын кредит тогтолцооны зарчимд нийцүүлэн суралцагчдын мэдлэг, дадлага, чадварыг суралцагчийн үнэлгээний нэгдсэн систем (СҮНС)-ээр үнэлж дүгнэнэ.

2.2. Суралцагчийн сурлагын амжилтыг зөвхөн нэг хичээлийн дүнгээр биш тухайн улиралд үзсэн бүх хичээлийн үнэлгээний голч дүнгээр дүгнэнэ.

2.3. Суралцагчийн мэдлэг, чадварыг дүгнэхдээ стандарт ба стандарт бус үнэлгээг хэрэглэнэ. Үүнд: А, В, С, D, F нь стандарт үнэлгээ, E, NC, CR, W, R нь стандарт бус үнэлгээ байна.

Хүснэгт 1

Суралцагчийн мэдлэг, чадварыг дүгнэхэд дараах лавлах хүснэгтийг ашиглана.

| Оноо | Тоон дүн | Үсгэн дүн | Үнэлгээний болзол |
|------------------------------------|-----------------------|-----------|--|
| 97, 98, <u>99</u> , 100 | 3,9, <u>4,0</u> | A | Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг дээд зэрэг бүрэн гүйцэд, бүтээлчээр ойлгосон, ухагдахуун, ойлголтуудыг чадварлаг ашигладаг; |
| 90, 91, <u>92</u> , 93, 94, 95, 96 | 3,6, <u>3,7</u> , 3,8 | A- | |
| 87, 88, <u>89</u> | 3,4, <u>3,5</u> | B+ | Дундаж түвшнөөс дээгүүр амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгосон, тухайн хичээлтэй холбоотой бодлого бодох ухагдахууныг ашиглах чадвартай; |
| 83, 84, <u>85</u> , 86 | 3,2, <u>3,3</u> | B | |
| 80, 81, <u>82</u> | 3,0 <u>3,1</u> | B- | |
| 77, <u>78</u> , 79 | 2,7, <u>2,8</u> , 2,9 | C+ | Тухайн хичээлийн агуулгыг дундаж түвшинд |

| | | | |
|----------------------------------|--------------------------------------|----|---|
| 74, <u>75</u> , 76 | 2,4, <u>2,5</u> , 2,6 | C | Эзэмшсэнийг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахууны ихэнхи хэсгийг хангалттай ойлгосон, дундаж түвшин бодлогуудыг бодох чадвартай, цаашид энэ чиглэлээр хичээл судлах хангалттай бэлтгэлтэй; |
| 70, <u>71</u> , 72, <u>73</u> | 2,0, <u>2,1</u> , 2,2, <u>2,3</u> | C- | |
| 67, 68, 69 | 1,9 | D+ | Дундаж түвшинд дөхсөн амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахуунуудыг жигд ойлгоогүй, харьцангуй хялбар бодлого бодох чадвартай ерөнхийдөө мэдлэг, чадвар, дадал дутмаг; |
| 63, 64, 65, 66, | 1,8 | D | |
| 60, 61, 62 | 1,7 | D- | |
| 0-59 | 0 | F | Мэдлэг, чадвар, дадал хангалтгүйг илтгэх дүн. |

Хүснэгт 2.

Стандарт бус үнэлгээг дараах тохиолдолд хэрэглэнэ.

| | |
|------|--|
| “E” | <u>(exam incomplete by the student)</u> Шалгалт өгөөгүй. Хүндэтгэн үзэх шалтгаанаар шалгалтад ороогүй бол энэ тэмдэглэгээг тавина. E үнэлгээтэй суралцагчийн холбогдох бичиг баримтыг үндэслэн нөхөн шалгалтад оруулна. |
| “NC” | <u>(non credit)</u> Өөр сургуулийн кредитийг тооцохгүй. Магадлан итгэмжлэлд орсон их, дээд сургуулиудаас шилжин ирсэн суралцагчийн кредитийг тооцох боломжгүй тохиолдолд тухайн хичээлийг төлбөртэйгээр нөхөн суралцаж, шалгалтаа журмын дагуу өгч үнэлүүлэхэд хэрэглэнэ. |
| “CR” | <u>(credit granted)</u> Өөр сургуулийн кредитийг тооцох Магадлан итгэмжлэлд орсон их, дээд сургуулиудаас шилжин ирсэн суралцагчийн кредитийг тооцох боломжтой тохиолдолд хэрэглэнэ. (улирлын голч дүнг бодоход оруулахгүй) |
| “W” | <u>(withdrawal)</u> Хичээлийн явцад суралцахаас татгалзаж орхисон. Оюутан ямар нэг шалтгаанаар хичээлдээ суугаагүй, цаашид суралцах эсэх нь тодорхойгүй тохиолдолд багш шууд “W” тэмдэглэгээ тавина. |
| “R” | <u>(repeating a course)</u> дахин судлах. Суралцагч тухайн хичээлийг дараагийн улиралд дахин судлахаар шийдсэн тухайгаа шалгалтын өмнө хэлж тэмдэглүүлнэ. Дахин судлах хичээлийг шинээр судлах хичээлийн адил бүртгэж тооцно. |

2.4. E тэмдэглэгээтэй суралцагч дараагийн улирлын эхний 21 хоногт багтаан шалгуулахгүй бол сургалтын албанаас F дүн тавина. Энэхүү нөхөн шалгалтад төлбөр төлөхгүй.

2.5. Стандарт бус үсгэн тэмдэглэгээтэй хичээлийн кредитийг улирлын болон нийт голч дүнг бодоход хэрэглэхгүй.

**ГУРАВ. СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ДАДЛАГА,
ЧАДВАРЫН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ.**

3.1. Явцын үнэлгээний дүн нь суралцагчийн хичээлийн агуулгыг тасралтгүй, жигд судлан эзэмшиж, эзэмшсэн мэдлэг, дадлага, чадвараа тухайн хичээлийн хөтөлбөр-стандартад тусгасан хэлбэрээр, заасан хугацаанд бодитой үнэлүүлэхэд чиглэгдэнэ.

3.2. Суралцагчийн сурах үйл ажиллагаа нь хичээлийн ерөнхий хуваарь болон бие даалтын хуваарийн дагуу явагдана.

3.3. Хичээлийн агуулгыг бүрэн эзэмшүүлэхийн тулд багш суралцагчидтай тогтмол ажиллаж, тэдний суралцах идэвх, чармайлт, мэрийлтийг дэмжиж, өөрөө өөртөө дүгнэлт хийх боломж олгох зорилгоор амаар, бичгээр, ярилцлага, тест, бодлого, тооцоо, дасгал, биеэр гүйцэтгэх дадлагын хэлбэрээр явцыг дүгнэнэ.

3.4. Багш тухайн хичээлийн хөтөлбөр стандартад тусгагдсан лекц, семинар, бүлгийн дасгал, дадлага, лабораторын ажлыг хэрхэн гүйцэтгэх, бие даалтын төлөвлөгөөний дагуу бодлого, зураг тооцоо, дасгал, бодит жишээн дээр суралцаж, судалгааны тайлан, илтгэл, эссэ, реферат, хяналтын ажил, явцын шалгалтыг хэдэн удаа авч ямар аргаар дүгнэх талаар тодорхой тусгаж өгнө.

3.5. Улирлын туршид суралцагчийн мэдлэг чадварыг дүгнэхэд багшийн үнэлгээ нь 60 хувийн оноотой тэнцүү байх бөгөөд онолын ба дадлагын үнэлгээ гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ.

3.6. Онол, дадлагын үнэлгээний харьцаа нь хичээлийн онцлогоос хамаарч дараах харьцаатай байна.

Хүснэгт 3.

| Хичээлийн нэр | Онолын мэдлэгийн үнэлгээний хувь | Дадлага чадварын үнэлгээний хувь |
|------------------------------|----------------------------------|----------------------------------|
| Цэргийн мэргэжлийн хичээл | 30-50 | 70-50 |
| Инженерийн мэргэжлийн хичээл | 40-50 | 60-50 |
| Нийгмийн ухааны хичээл | 50-70 | 30-50 |
| Биеийн тамрийн хичээл | 10 | 90 |

Явцын 60 онооны үнэлгээг онол, дадлагын үнэлгээний нийлбэрээр дээрх хувь, харьцаагаар бодож гарна.

3.7. Онолын мэдлэгийн үнэлгээ нь дараах үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

$$E_{60} = C_1 + C_2 + C_3 \quad (1)$$

E_{60} – Явцын үнэлгээний 60 хувийг тухайн хичээлийн онцлогоос хамаарч дараах байдлаар үнэлж болно. Бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимүүд мэргэшүүлэх зарим нэг хичээлд багшийн үнэлгээг 50, хөндлөнгийн шалгалтын үнэлгээг 50 хувиар тус тус тогтоож болно.

Хүснэгт 4.

| Тэмдэглэгээ | Үнэлгээний үзүүлэлт | Үнэлэх хэлбэр | Оноо | | |
|----------------|--|--|---------------------------|----------------------|------------------------------|
| | | | Нийгмийн ухааны чиглэлээр | Инженерийн чиглэлээр | Цэргийн мэргэжлийн чиглэлээр |
| C ₁ | Хичээлийн ирц, идэвх, оролцоо | Лекц, семинар бүлгийн дасгал, дадлага бие даалтын хичээлийн ирц, оролцоо үр дүнгээр | 30 | 10 | 10 |
| C ₂ | Онолын мэдлэг, түвшин, даалгаварын биелэлтийн чанар үр дүн | Бичгийн ажил хийх, асууж ярилцах, тест хяналтын ажил, сорил, бодлого, зураг тооцоо, дасгал, эссэ, илтгэл тавиулах, лаборатори, дадлага ажлын тайлан хамгаалуулах, биеэр хийж гүйцэтгэх дадлагын ажил гэх мэт хэлбэрээр | 10 | 20 | 30 |
| C ₃ | Бие даалт | Бодлого, бодит жишээн дээр суралцах, график тооцооны ажил гүйцэтгэх, орчуулга хийх судалгааны болон ангийн ажил, төсөл бичиж хамгаалах гэх мэт хэлбэрээр | 20 | 30 | 20 |

Тайлбар: Явцын үнэлгээгээр 50-аас дээш оноо авсан суралцагч хөндлөнгийн үнэлгээний шалгалтад 15-аас доош үнэлгээтэй шалгагдвал явцын үнэлгээг хүчингүйд тооцож тухайн оюутныг давтан сургалтад хамруулна.

3.8. Дадлагын үнэлгээг суралцагч тухайн хичээл дээр биеэр хийж сурсан байвал зохих дадлага ажлуудыг нэг бүрчлэн шалгуулж үнэлүүлнэ.

3.9. Тодорхой хичээлээр сонсогч, оюутны заавал биеэр хийж сурсан байх дадлага ажлууд, ажил бүрийг гүйцэтгэх дараалал, журам, нормативийг тухайн хичээлээр эзэмшсэн байх дадлага, чадварын стандарт гэнэ. Суралцагч дадлага ажил бүрийг гүйцэтгэх заавар, журмын дагуу нэг бүрчлэн шалгуулж авбал зохих үнэлгээний 90%-с дээш үнэлгээтэй шалгуулснаар стандартыг хангасанд тооцогдоно.

3.10. Цэргийн мэргэжлийн хичээлээр дадлага, чадварын стандартыг хангаагүй сонсогчид улирлын шалгалтад орох эрх олгогдохгүй.

3.11. Багш зааж буй хичээлийн кредитээс хамааран хичээл (улирал)-ийн явцад суралцагч бүрт 1 кредит цагийн хичээлд 2-оос, 2 кредит цагийн хичээлд 4-оос, 3 кредит цагийн хичээлд 6-аас доошгүй дүн тавьсан байна.

3.12. Багш энэхүү журмын 3.4, 3.5, 3.6-д заасан үнэлгээний зарчмыг үндэслэн хичээл (улирал)-ийн эхэнд “Багшийн программ”-ын тохируулгыг хийж, суралцагчийн явцын үнэлгээг цаг тухайд нь оруулна.

3.13. Суралцагч явцын үнэлгээнийхээ талаарх мэдээллийг “Сонсогч, оюутны программ”-аас тухай бүрт харж болно.

ДӨРӨВ. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ.

4.1. Хичээл бүрийн төгсгөлд заавал хөндлөгийн үнэлгээ хийлгэнэ. Хөндлөнгийн үнэлгээ нь 40 хүртэлх хувиар үнэлэгдэнэ. Хөндлөнгийн үнэлгээний шалгалт улиралд нэг удаа явагдах учир улирлын шалгалт гэх ба тухайн хичээл хаагдаж байвал хаагдах шалгалт гэнэ. Энэ нь улирлын эхэн, сүүл, төгсгөл хэсэгт явагдаж болох ба хичээл дууссны дараа залгуулан явагдана. /Тухайн хичээлийн кредит цагтаа багтаж байна./

4.2. Улирлын шалгалтын зорилго нь:

- Суралцагч хичээлийн стандарт хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшсэн эсэхийг хөндлөнгөөс үнэлэх;
- Багшаас суралцагчийн явцын үнэлгээг бодитой үнэлсэн эсэхэд хяналт тавих;
- Багшийн сургах, суралцагчийн суралцах үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх;
- Суралцагчийн мэдлэг, дадлага, чадварыг дүгнэх 100 хувийн үнэлгээг бүрдүүлж баталгаажуулах;

4.3. Явцын үнэлгээний 60 хувийн дүнгээр 36-аас дээш хувийн үнэлгээ авсан суралцагчийг хөндлөнгийн үнэлгээний (улирлын) шалгалтад оруулна.

4.4. Хөндлөнгийн үнэлгээний шалгалтын хэлбэрийг тухайн хичээлийн онцлог, улирлын болон хаагдах хичээлийн аль байхаас хамааран тогтоож авна. Үүнд:

- Ерөнхий суурь хичээлийн шалгалтыг тестээр, мэргэжлийн суурь хичээлийн шалгалтыг тест, аман хэлбэрийн аль нэгээр;
- Мэргэшүүлэх хичээлийн шалгалтыг бичгийн болон аман (асуулт бүхий билет, ярилцлага, тодорхой бодлого, даалгавар гүйцэтгэх) хэлбэрээр авна.
- Цэргийн мэргэжлийн хичээлийн шалгалтыг онол, дадлагаар авна. Онолын хэсгийг аман, бичгийн, тестийн хэлбэрийн аль нэгээр авч болно.

4.5. Хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг комисс авах бөгөөд шалгагч багш, ассистентийг тухайн сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын алба СБЗА-тай зөвшилцөн томилно.

4.6. Хөндлөнгийн үнэлгээний шалгалтын тест, билет бусад материалын санг бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын албад хичээл тус бүрээр нь бүрдүүлэн мэргэжлийн тэнхимийн даргаар хянуулж, СБЗА-ны даргаар баталгаажуулан нууцлалыг хадгална. Бататгах шалгалтын тест, билетийн санг ИӨУАлба бүрдүүлнэ.

4.7. Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн боловсруулах бүрт тест, билет, шалгалтын материалын санд баяжилт хийж шалгалт авна.

4.8. Тест болон бичгээр шалгалт авах шалгалтын хугацаа судалсан хичээлийн агуулгаас хамаарч 90 хүртэлх минут байна. Шалгалтыг билетээр, амаар авах тохиолдолд нэг цагт 6 суралцагч шалгагдсан байхаар зохион байгуулна.

4.9. Хөндлөнгийн үнэлгээний шалгалтын комисс дүнг ажлын 2 өдөрт багтаан “Багшийн программ”-д оруулж хичээл заасан багш суралцагчийн сурлагын дэвтэрт бичилт хийж гарын үсгээр баталгаажуулна.

4.10. “Багшийн программ”-д оруулсан дүнг үндэслэн суралцагчийн тухайн улирлын рейтингийн оноо, цуглуулсан кредит, үнэлгээний голч дүнг бүрэлдэхүүн

сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын албад бодож баталгаажуулан "Сонсогч, оюутны программ"-д оруулна.

ТАВ. СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ДАДЛАГА, ЧАДВАРЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ.

5.1. Ерөнхий үнэлгээ нь явцын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээний нийлбэр оноогоор дүгнэгдэж энэ журмын 2.3.-д заасны дагуу харгалзах онооны үнэлгээг авна.

5.2. Ерөнхий үнэлгээгээр 3-аас дээш хичээлд "F" үнэлгээ авсан суралцагч БХИС-ийн дотоод журмын 6.11-ийн а, БХИС-ийн бакалаврын журмын 10.2-д заасны дагуу сургуулиас хасна.

5.3. Тухайн хичээлийн явцын дүн нь 35 онооноос доош бол тухайн сонсогч, оюутан шалгалт өгөх эрх эдлэхгүй бөгөөд суралцагч давтан сургалтад хамрагдана. Давтан сургалтад хамрагдах хичээлийн тоо 2-оос ихгүй байна.

5.4. Суралцагч ерөнхий үнэлгээгээр F үнэлгээ авсан тохиолдолд тухайн хичээлийн явцын үнэлгээний дүн 36-аас доошгүй үнэлгээтэй бол дахин шалгалтын төлбөр тухайн хичээлийн жилийн багц цагийн үнэлгээний 30 хувиар тооцон төлж зөвхөн нэг удаа шалгалт өгөх эрх эдлэнэ.

ЗУРГАА. ДАВТАН СУРГАЛТ.

6.1. БХИС-ийн суралцагч давтан сургалтаар (Fүнэлгээтэй) ямар хичээлийг сонгож дахин судлах хүсэлтэй байгаа тухайгаа өргөдөл гаргаж, өөрийн сургуулийн "Эрдэм шинжилгээ сургалтын алба"-д өөрийн биеэр өгнө.

6.2. БХИС-ийн СБЗА-аас зуны давтан сургалтад хамрагдан суралцах хүсэлт гаргасан оюутны хичээл сонголтыг үндэслэн тухайн хичээлийг хариуцан явуулах бүрэлдэхүүн, хичээл заах багш, сургалтын хичээлийн хуваарийг сургуулийн ЭШСА, мэргэжлийн тэнхмийн саналыг харгалзан тушаалаар гаргана.

6.3. Давтан сургалтыг хичээлийн жил бүрийн Сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд нийт 4 долоо хоногт багтаан зохион байгуулна.

6.4. Давтан сургалтад тухайн оюутны судалж үзэх хичээлүүдийн тоо 2-оос ихгүй байх шаардлагад бүрэлдэхүүн сургуулийн ЭШСА хяналт тавьна.

6.5. Багш тухайн хичээлийн шалгалтын болон дүнгийн хуудсыг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд өөрийн биеэр хүргэнэ.

6.6. Давтан сургалтын 1 кредит цагийн үнэлгээ нь тухайн жилийн БХИС-ийн оюутны 1 кредит цагийн үнэлгээний 60 хувиар бодож төлбөрийн тооцоо хийнэ.

6.7. Дахин шалгалт авсан мөн давтан сургалтад хичээл заасан багшийн кредит нь хичээлийн жилийн ноогдлын гүйцэтгэлд орж тооцогдохгүй ба багшид тухайн хичээлээр шалгалт өгсөн болон сургалтад хамрагдсан оюутнуудын кредит цагийн нийт төлбөрийн 15 хувиар бодож ажлын хөлс олгоно.

ДОЛОО. СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ГОЛЧ ДҮН

7.1. Суралцагчийн сурлагын чанарыг харуулах гол үзүүлэлт нь үнэлгээний голч дүн (ҮГД) мөн. Суралцагчийн үнэлгээний голч дүн улирал бүрт болон суралцсан хугацааны хуримтлуулсан дүнгээр тооцогдох бөгөөд мэргэжлийн хөтөлбөрийн агуулга эзэмшилтийн чанарын түвшинг тогтооход ашиглана.

7.2. Улирлын үнэлгээний голч дүн (УҮГД)-г тооцохдоо:

Хичээл бүрээр үсгэн үнэлгээг тоон дүнд шилжүүлэн улмаар тухайн хичээлийн харгалзах кредитээр үржүүлж дундажлах замаар тодорхойлно. УҮГД-г дараах томъёогоор зууны нарийвчлалтайгаар тооцно.

$$\text{Үнэлгээний голч дүн(GPA)} = \frac{\text{чанарын онооны нийлбэр}}{\text{кредит цагийн нийлбэр}}; \text{ буюу } \text{GPA} = \frac{Y_1 * K_1 + Y_2 * K_2 + \dots + Y_n * K_n}{K_1 + K_2 + \dots + K_n};$$

Үүнд:

Y_1, Y_2, \dots, Y_n - тухайн хичээлүүдийн харгалзах тоон дүн;

K_1, K_2, \dots, K_n - тухайн хичээлүүдийн харгалзах кредит цаг

СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА